

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны дугаар сарын-ний өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах, нөөц бүрдүүлэх, зарцуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт, нөөц бүрдүүлэлт, зарцуулалтын тухай хууль тогтоомж

2.1.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, нөөц бүрдүүлэлт, хадгалалтын тухай хууль тогтоомж нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, Барилгын тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль, Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, Улсын нөөцийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, нөөц бүрдүүлэлт, хадгалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад энэ хууль үйлчилнэ.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."газрын тосны бүтээгдэхүүн" гэж газрын тос, байгалийн хий, тэдгээрийн нэгдлүүдийг боловсруулах замаар гарган авсан бүх төрлийн шатахуун, завсрын /дайвар/ бүтээгдэхүүн, тусгай шингэн, шингэрүүлсэн шатдаг хий, тосолгооны материал, битум, мазут болон бусад бүтээгдэхүүнийг; ЭСВЭЛ /"газрын тосны бүтээгдэхүүн" гэж газрын тос, хийг боловсруулах замаар гарган авсан бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хий, мазут, битум, тос боловсруулах үйлдвэрийн бусад түүхий эд болон нэрдэс /дистилат, **distillates**/ зэрэг нүүрсустөрөгчийн холимгийг,/ /"нэрдэс" гэж газрын тос боловсруулах үйлдвэрийн шууд нэрлэгээс гарсан бүтээгдэхүүнийг, /

4.1.2.“бүх төрлийн шатахуун” гэж боловсруулах үйлдвэрт технологийн дагуу боловсруулагдсан эцсийн бүтээгдэхүүн буюу автобензин, дизелийн түлш, онгоцны түлшийг,

4.1.3.“шатдаг хий” гэж байгалийн хий, нефтийн дагалдах хийг боловсруулах үйлдвэрт технологийн дагуу боловсруулагдсан эцсийн бүтээгдэхүүн буюу шингэрүүлсэн хийг,

4.1.4.“тоног төхөөрөмж” гэж газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах, чанарын шалгалт хийхэд ашиглах шахуурга, түгээгүүр, хэмжих, тохируулах, ачих, буулгах хэрэгсэл, хадгалах сав, дамжуулах хоолой, хаалт зэрэг механик болон автомат ажиллагаатай техник хэрэгслийг;

4.1.5.“онцгой тохиолдол” гэж гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдлын улмаас газрын тосны бүтээгдэхүүний импортын тасалдал, нийлүүлэлт хангамжид хомсдол үүсэхийг;

4.1.6.“стратегийн нөөц” гэж онцгой тохиолдлын үед хэрэглэгчдийг хангах зорилгоор энэ хуульд заасан зориулалт, нөхцлийн дагуу бүрдүүлж, зарцуулах газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг,

4.1.7.“компанийн нөөц” гэж бүх төрлийн шатахуун, шатдаг хий импортлох, бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хангамж, түгээлтийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардагдах хэмжээний тухайн этгээдийн эзэмшлийн агуулах, саванд хадгалагдаж байгаа бүтээгдэхүүнийг;

4.1.8.“Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж бүх төрлийн шатахууныг импортлох, үйлдвэрлэх, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэхээр *эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан* этгээдийг;

4.1.9.“газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа” гэж газрын тосны бүтээгдэхүүнийг нэг удаад тээврийн хэрэгслийн нэг торхны хэмжээнээс багагүй хэмжээгээр борлуулалт хийхийг.

4.1.10.“агуулах” гэж газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх ачих, савлах, бөөний худалдаа эрхлэх зориулалттай үндсэн байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн цогцолборыг,

4.1.11.“түгээх станц” гэж бүх төрлийн шатахуун, шатдаг хийг хүлээн авах, хадгалах, тээврийн хэрэгслийг цэнэглэх, жижиглэнгийн худалдаа эрхлэх зориулалттай барилга, байгууламж, техник тоног, төхөөрөмжийн цогцолборыг,

4.1.12.“жижиглэнгийн худалдаа” гэж бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг шатахуун түгээх станц, хий цэнэглэх станцаар борлуулалт хийхийг,

4.1.13.“хий цэнэглэх цэг” гэж ахуйн хэрэглээний шатдаг хийг баллонд цэнэглэх, борлуулах зориулалттай техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн цогцолборыг,

4.1.14.“стратегийн нөөц бүрдүүлэлтийн зээл” гэж газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх зориулалттай зээлийг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ТЭЭВЭРЛЭЛТ, ХАДГАЛАЛТЫН ТАЛААРХ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

5 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаархи Засгийн газрын бүрэн эрх

5.1.Газрын тосны бүтээгдэхүүний талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт, стратегийн нөөц бүрдүүлэлтийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2.бүх төрлийн шатахуун, шатдаг хийн стратегийн нөөц бүрдүүлэх журам батлах;

5.1.3.бүх төрлийн шатахуун, шатдаг хийн бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн нөөцийн хэмжээ, нөөц бүрдүүлэх журмыг батлах;

5.1.4.бүх төрлийн шатахуун, шатдаг хийн **үнийн огцом өсөлт**, хангамжийн тасалдал, нийлүүлэлтийн хомсдол үүсэх нөхцөлд ??? зохицуулалт хийх;

5.1.5.импортолж байгаа бүх төрлийн шатахуун, шатдаг хийн чанарын хяналтыг хилийн боомтуудад хийх бодлогыг хэрэгжүүлэх, нөхцлийг бүрдүүлэх.

5.1.6.Засгийн газар газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стратегийн нөөцийн нэр төрөл, хадгалах байршил, хэмжээг тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр жил бүр шинэчлэн тогтооно.

5.1.7. бүх төрлийн шатахуун, шатдаг хийн стратегийн нөөцийн зээлийг улсын төсөв, Засгийн газрын нөөц хөрөнгө, тусгай сангийн санхүүжилтийн эх үүсвэрээр бүрдүүлнэ.

6 дугаар зүйл.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

6.1.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын тосны бүтээгдэхүүний талаар дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт, стратегийн нөөц бүрдүүлэлтийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх;

6.1.2.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бүх бүх төрлийн шатахуун, шатдаг хийг импортлох, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

5.2.3.газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын асуудалтай холбогдсон дүрэм, журам, нормыг баталж, мөрдүүлэх;

5.2.4. бүх төрлийн шатахуун, шатдаг хийн бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн стратегийн нөөцийн талаар санал боловсруулан Засгийн газраар шийдвэрлүүлж хэрэгжүүлэх;

5.2.5.газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг баталж мөрдүүлэх.

5.3.Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавих техникийн шаардлагыг тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран тогтооно.???

5.4.Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага стратегийн нөөцийн бүртгэлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн стратегийн нөөцийн мэдээ, тайлан гаргах маягт, гэрээний үлгэрчилсэн загварыг батална.

5.5.Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн явцад тусгай зөвшөөрөл шинээр авсан хуулийн этгээдийн бүрдүүлэх стратегийн нөөцийн нэр төрөл, хадгалах байршил, хэмжээг түр тогтооно.

5.6.Стратегийн нөөцийг тогтоохдоо тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмнөх онд импортоор оруулсан, худалдсан газрын тосны бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг үндэслэн газрын тосны бүтээгдэхүүний төрөл тус бүрээр тооцно.

7 дугаар зүйл.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

7.1.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, бүх төрлийн шатахуун, шатдаг хийн худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.газрын тосны бүтээгдэхүүний талаархи бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

7.1.2.газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалахтай холбоотой стандарт, дүрэм, журам, нормын төслийг боловсруулах;

7.1.3.газрын тос, газрын тос боловсруулах үйлдвэр, бүх төрлийн шатахуун, шатдаг хийн агуулах, түгээх станцад техник, технологийн талаар дүгнэлт гаргах,

7.1.4.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх, бүх төрлийн шатахуун, шатдаг хийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход мэргэжлийн дүгнэлт гаргах;

7.1.5.газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд ажиллах;

7.1.6.газрын тосны бүтээгдэхүүний импорт, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаар мэдээллийн сан бүрдүүлэх, бодлого зохицуулалтад шаардлагатай нэмэлт судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;

7.1.7.газрын тосны бүтээгдэхүүний зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийг Өрсөлдөөний тухай хуулийн 15.1.8-д заасны дагуу холбогдох байгууллага болон төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх, энэ талаар санал гаргах;

7.1.8.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх, бүх төрлийн шатахуун, шатдаг хий импортлох, худалдах, тээвэрлэх, хадгалах талаар сургалт явуулах, мэдээлэл арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх;

7.1.9.газрын тосны бүтээгдэхүүний олон улсын биржийн үнийг судлах, импортлогчийн нийлүүлэгчээс худалдан авах үнийг хянах.

7.1.10.”газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтад чанарын хяналт хийх.

7.2.Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ИМПОРТЛОХ ҮЙЛДВЭРЛЭХ, ХУДАЛДАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ

8 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох

8.1.Бүх төрлийн шатахуун, шатдаг хийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр импортлох бөгөөд импортлогч дор дурдсан үүрэг хүлээнэ:

8.1.1.чанарын хувьд олон улсын болон үндэсний стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох;

8.1.2.импортолсон бүх төрлийн шатахуун, шатдаг хий нь чанарын хувьд стандартад нийцсэн эсэх талаар итгэмжлэгдсэн сорилтын лабораториор дүгнэлт гаргуулах;

8.1.3.газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр импортлох.

8.2.Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний 30-аас дээш хувийг дангаараа нийлүүлж байгаа гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээлд өөрийн хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээд болон өөрийн харьяалал, хяналтад байдаг нэгжээрээ дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно.

8.3.Газрын тосны үйлдвэрлэлийн завсрын бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр импортлох бөгөөд тус тусгай зөвшөөрлийг газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд олгоно.

9 дүгээр зүйл.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх

9.1.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

9.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийн үндсэн болон дагалдах байгууламж, тоног төхөөрөмж, технологи нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, холбогдох стандартад нийцсэн байна.

9.3.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг үйлдвэрийн байгууламжийг барьж байгуулан улсын комисст хүлээлгэн өгсөн этгээдэд олгоно.

9.3.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан бичиг баримт бүрдүүлнэ:

9.3.1.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн дүгнэлт;

9.3.2.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төсөл;

9.3.3. мэргэжлийн байгууллагаар боловсруулж, улсын экспертизийн хяналт хийлгэж холбогдох байгууллагаар хянуулж баталгаажсан газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрийн барилга байгууламжийн иж бүрэн зураг төсөл, газар эзэмших зөвшөөрөл;

9.3.4.газрын хөрсний геологийн дүгнэлт;

9.3.5.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл нь эрүүл ахуйн шаардлага хангаж буй эсэхэд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт;

9.3.6.галын аюулгүй байдлын дүгнэлт.

9.4.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь үүрэг хүлээнэ:

9.4.1.үндэсний стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнийг эрх бүхий байгууллагын баталсан технологийн дагуу үйлдвэрлэх;

9.4.2.газрын тосны бүтээгдэхүүний чанарын шинжилгээ, туршилт хийх итгэмжлэгдсэн лабораторитой байх;

9.4.3.үйлдвэрийн хаягдлыг хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхээргүй орчинд хадгалах, зайлуулах, устгах нөхцөлийг бүрдүүлэх.

10 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүнийг худалдах

10.1.Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн бөөний болон жижиглэнгийн худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргагч нь энэ хуулийн 5.2.5-д заасан журам болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлнэ:

10.2.1. хэмжих хэрэгсэл, шингэний тоолуурыг Хэмжил зүйн тухай хуулийн дагуу загварын туршилтад хамруулсан бичиг баримт;

10.2.2.стандартын шаардлага хангасан агуулах, түгээх станцын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл эдгээрийн түрээсийн гэрээ.

10.3.Газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч дараахь үүрэг хүлээнэ:

10.3.1.бүх төрлийн шатахуун, шатдаг хийн бөөний худалдаа эрхлэгч бүтээгдэхүүн борлуулах тухай бүрдээ худалдан авагчид чанарын гэрчилгээ олгох;

10.3.2. чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн худалдах;

10.3.3. бүх төрлийн шатахуун, шатдаг хийг улсын баталгаатай түгээгүүрээр худалдах;

10.3.4. бүх төрлийн шатахуун, шатдаг хийг баталгаагүй түгээгүүр, авто болон вагонцистернээс шууд худалдахгүй байх;

10.3.5. бүх төрлийн шатахуун, шатдаг хийг стандартын шаардлага хангасан саванд хадгалж, зөвшөөрөгдсөн талбай, орчинд худалдах;

10.3.6. тос, тосолгооны материал, тусгай шингэнийг зөвхөн зориулалтын саванд үйлдвэрийн аргаар технологийн дагуу савлаж худалдах;

10.3.7. бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бүх төрлийн шатахуун, шатдаг хийн чанарын шинжилгээний лабораторитой байх.

10.3.8. битум, мазутыг хүлээн авах, хадгалах, ачих зориулалттай үндсэн байгууламж, тоног төхөөрөмж бүхий агуулахтай байх,

10.3.9. бүх төрлийн шатахуун, шатдаг хийн бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эзэмшилдээ стандартын шаардлага хангасан агуулахтай байх.

10.4. Газрын тосны боловсруулах үйлдвэрийн түүхий эд, завсрын /дайвар/ бүтээгдэхүүнийг зориулалтын агуулахад хадгална,

10.5. Газрын тос боловсруулах үйлдвэрийн завсрын бүтээгдэхүүнийг агуулахын саванд үйлдвэрлэлийн технологийн бус аргаар хольж, найруулан шатахуун нэрээр худалдан, борлуулахыг хориглоно.

11 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх

11.1. Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

11.2. Зориулалтын саванд савласан тос, тосолгооны материал, хийг аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тэвш, чингэлэгт тээвэрлэнэ.

11.3. Тээвэрлэгч тээвэрлэлтийн талаар эрх бүхий байгууллагаас батлан гаргасан техникийн аюулгүй ажиллагаа, тээвэрлэлтийн нөхцөлтэй холбогдсон дүрэм, журам, стандартын үзүүлэлт, шаардлагыг хангана.

11.4. Тээвэрлэгч зориулалтын тээврийн хэрэгсэлд тогтоосон журмын дагуу таних тэмдэг тавина.

11.5. Тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, жолооч тээврийн хэрэгслийг галын аюулаас урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, иргэдийн эрүүл мэнд, амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангасан зориулалтын зөвшөөрөгдсөн байр, зогсоол, талбайд тавина.

11.6. Тээвэрлэгч тээвэрлэж байгаа газрын тосны бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг тодорхойлсон гэрчилгээ бөөний худалдаа эрхлэгчээс авна.

11.7.Газрын тосны бүтээгдэхүүнийг нийтийн тээврийн хэрэгсэл болон стандартын шаардлага хангаагүй зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг хориглоно.

12 дүгээр зүйл.Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах

12.1.Газрын тосны бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, саванд хадгална.

12.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч стратегийн нөөцийг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд, технологийн горимын дагуу сэлгээ хийж хадгална.

12.3.Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага стратегийн нөөцөд байгаа газрын тосны бүтээгдэхүүний чанарт хийсэн шалгалтыг үндэслэн шаардлагатай гэж үзвэл тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүтээгдэхүүнийг бүрэн сэлгүүлэх хугацаатай үүрэг өгч болно.

12.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хадгалалтын үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг чанд мөрдөн ажиллах бөгөөд гарах зардал, эрсдлийг бүрэн хариуцна.

12.5.Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах агуулах эзэмшигч хуулийн этгээд дор дурдсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй:

12.5.1.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх;

12.5.2.газрын хөрсний геологийн дүгнэлтийг эрх бүхий байгууллагаар хийлгэх;

12.5.3.эрх бүхий мэргэжлийн байгууллагаар боловсруулж, улсын экспертиз буюу улсын магадлан шалгалтын хяналт хийлгэсэн зураг, төслийн дагуу барьсан байх, газар эзэмших зөвшөөрөлтэй байх;

12.5.4.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл нь эрүүл ахуйн шаардлага хангаж буй эсэхэд мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулах;

12.5.5.галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах;

12.5.6.агуулах, шатахуун түгээх станцын барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан тухай улсын комиссын дүгнэлт, барилга байгууламжийн үндсэн бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөв байдлыг тодорхойлсон техникийн дүгнэлттэй байх.

12.5.7.бүх төрлийн шатахуун хадгалах зориулалтын саванд газрын тосны боловсруулах үйлдвэрийн завсрын /дайвар/ бүтээгдэхүүн хадгалахыг хориглоно.

12.6.Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савыг өмчлөгч савыг улсын бүртгэлд бүртгүүлнэ. Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зориулалтын савыг улсын бүртгэлд бүртгэх журмыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлана..

12.7.Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалахад дараах зүйлийг хориглоно:

12.7.1.зориулалтын бус барилга байгууламжид, мөн улсын комисс хүлээн аваагүй барилга байгууламжид газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах;

12.7.2.стандартын шаардлага хангаагүй, эрх бүхий байгууллагаас олгосон шалгалт тохируулгын гэрчилгээгүй нөөцлөх саванд хадгалах;

12.7.3.нэвчилт, шүүрэлттэй дамжуулах хоолой ашиглах;

12.7.4.аянга зайлуулагч, газардуулгын байгууламжийн далд ажлын актын дүгнэлтгүй, эсвэл газардуулгын байгууламжгүй, уг байгууламжийн эсэргүүцлийг нь мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлж баталгаажуулаагүй сав, тоног төхөөрөмж ашиглах;

12.7.5 бүх төрлийн шатахуун, шатдаг хийг автоцистернээс газардуулгагүй буулгах;

12.7.6.газрын тосны бүтээгдэхүүнийг зориулалтын буулгах байгууламжгүй саванд буулгах.

12.7.7.газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах, түгээх станцын барилга байгууламжийн угсралтын ажлын зураг төсөлгүй эхлэх, зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

13 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний холбоотой үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг үүрэг

13.1.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч, худалдагч, бүтээгдэхүүн хадгалж байгаа этгээд дахин ашиглахаа больсон агуулах, сав, тоног төхөөрөмжийг зайлуулах, газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдлийг цэвэрлэх, газрыг тэгшилж хөрсийг хэвийн байдалд оруулан хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөлгүй болгох, бохирдсон болон эвдэрч гэмтсэн газрын хөрсийг нөхөн сэргээж ургамалжуулах үүрэгтэй.

13.2.“Газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэгч нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл багатай, экологийн өндөр ангилал бүхий чанар, стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх үүрэгтэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НӨӨЦ

14 дүгээр зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний нөөц

14.1.Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн нөөц нь стратегийн болон компанийн нөөцөөс бүрдэнэ.

14.2.Стратегийн нөөц бүрдүүлэх журмыг Засгийн газар батална. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг журмын дагуу стратегийн нөөцийг бүрдүүлнэ.

14.3.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх бүх төрлийн шатахуун, шатдаг хийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу компанийн нөөцийг бүрдүүлнэ.

14.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өдрийн дундаж импортын 90 хоног, эсвэл өдрийн дундаж борлуулалтын 61 хоногийн аль их хэмжээгээр стратегийн нөөц бүрдүүлнэ.

14.4.Энэ хуулийн 13.3-д заасан өдрийн дундаж импортын болон худалдааны хэмжээг хуанлийн жил бүрийн 1 дүгээр сарын 1-ээс 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны тоо хэмжээг үндэслэн тогтоох бөгөөд холбогдох аргачлалыг Засгийн газар батална

14.5.Стратегийн нөөцийг тогтоохдоо тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмнөх онд импортолсон, худалдсан газрын тосны бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг үндэслэн газрын тосны бүтээгдэхүүний төрөл тус бүрээр тогтооно.

14.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч стратегийн нөөц хадгалж байгаа тухайн савны үлдэгдлийг тогтоосон хэмжээнээс бууруулахгүй байх үүрэгтэй бөгөөд шаардлагатай гэж үзвэл газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдсний үндсэн дээр өөр саванд шилжүүлж болно.

14.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч стратегийн нөөц бүрдүүлэх санхүүгийн эх үүсвэрийг хариуцна.

14.10.Стратегийн нөөц бүрдүүлэлтийн зээлийн эргэн төлөлтийн баталгааг Засгийн газар гаргаж болно.

14.11.Тусгай зөвшөөрөл эзэмшигч стратегийн нөөцийг онцгой тохиолдол үүссэн үед энэ хуулийн 6.3-т заасны дагуу нийлүүлэлтийн томоохон тасалдлын хүндрэлээс урьдчилан сэргийлэх, хүндрэлийг арилгах, эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зарцуулна

14.12.Стратегийн нөөц бүрдүүлэлтэд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж, санхүүгийн болон газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад мэдээлж байна.

14.13.стратегийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

14.14.стратегийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг Засгийн газрын нөөц хөрөнгө,

14.14.Стратегийн нөөц бүрдүүлэлтийн зээлийн эргэн төлөлтийн баталгааг Засгийн газар гаргаж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ТЭЭВЭРЛЭЛТ, ХАДГАЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

15 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтад тавих хяналт

15.1.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт болон эдгээр үйл ажиллагааны аюулгүй байдалд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

15.2.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтад тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийг баримтална.

15.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн стратегийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, бүтээгдэхүүний чанарт газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллага?? хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

16 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.